

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

2020.02.21 № 06/552  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх зээлийн санхүүжүүлтийн эх үүсвэрийг төсвийн шууд захирагчийн төсөвт төлөвлөж батлуулсныг сайдын багцад шилжүүлэн залруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 27-оос 2020 оны 1 дүгээр сарын 31-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга, хот байгуулалтын яам нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03/214 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуй, орон сууцны, инженерийн дэд бүтцийн, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбаруудын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Тус яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах.

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Барилга, хот байгуулалтын яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Барилга, хот байгуулалтын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Барилга, хот байгуулалтын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан

төсвийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,031,815.6 мянган төгрөгөөс тооцон 70,318.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 783,749.6 мянган төгрөгөөр буюу 81.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,695.0	3,642.0	(8,053.1)
Урьдчилгаа	25,308.5	15,137.5	(10,171.0)
Бараа материал	28,582.2	32,588.0	4,005.8
Үндсэн хөрөнгө	895,729.5	126,198.1	(769,531.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>961,315.2</b>	<b>177,565.6</b>	<b>(783,749.6)</b>
Өр төлбөр	5,371.3	-	(5,371.3)
Засгийн газрын хувь оролцоо	955,943.9	177,565.6	(778,378.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>961,315.2</b>	<b>177,565.6</b>	<b>(783,749.6)</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 769,531.4 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 249 дүгээр тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-т тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 616,820.5 мянган төгрөгийн барилгын сорилт, шинжилгээний лабораторын тоног төхөөрөмжийг шилжүүлснээс шалтгаалжээ.

Тайлант онд хөрөнгө оруулалтаар 13,941.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 8,514.6 мянга, нийт 22,456.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 177,565.6 мянган төгрөг болж 778,378.3 мянган төгрөгөөр буурсан нь Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-т барилгын сорилт, шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг шилжүүлснээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага хөтөлбөр”-т зориулан 7,031,815.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,029,963.3 мянган төгрөгийг урсгал зардалд, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д олгох 5,000,000.0 мянган төгрөгийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрт тус тус зарцуулахаар батлагджээ. Нийт зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,029,963.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь тээврийн хэрэгслийн даатгал, оношилгоо, татварын зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслөөс 19,856.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 16,214.8 мянган төгрөгийг зарцуулсан ба оны эцэст зарцуулагдаагүй 3,641.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн гүйцэтгэх үе шатанд 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа зөрчилтөйд тооцож зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

#### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь, 53 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,017.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 14,565.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга, аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгө ашиглалттай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тус яаманд "Дэд бүтэц төсөл" хэрэгжиж дууссантай холбогдуулан төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан Hundai sonata-7 маркийн автомашиныг 2016 оны 12 сард балансаас балансад шилжүүлэн орлого авсан боловч одоогоор албан хэрэгцээнд ашиглагдахгүй, 2019 оны 6 сард 6 жилийн ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3.7-д "... автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад саналаа хүргүүлж шийдвэрлүүлээгүйгээс хөрөнгө ашиглалтгүй эзэнгүйдэх,

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах,

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

## *2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал*

### 2.1. Илрүүлэлт:

Тайлант онд Түрээсийн орон сууц корпораци ТӨХХК-нд "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний дагуу олгох 5.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн шууд захирагч /аппарат/-ийн төсөвт төлөвлөж, батлуулсан байна.

Энэ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний 2.5-д "Зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

### 2.2. Эрсдэл:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн шууд захирагчийн төсөвт төлөвлөж батлуулснаас зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт сулрах, зээлийн эрсдэл үүсэх

### 2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Түрээсийн орон сууц корпораци ТӨХХК-нд олгох зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төлөвлөж, батлуулж байх

### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>65,585,764.66</b>	<b>51,367,447.09</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	11,695,045.00	3,641,950.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	853,095.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,841,950.00	3,641,950.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	25,308,547.66	15,137,483.09
34600	Урьдчилж гарсан зардал	25,308,547.66	15,137,483.09
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,582,172.00	32,588,014.00
35410	Бичиг хэргийн материал	5,703,875.00	6,492,325.00
35420	Аж ахуйн материал	1,494,640.00	1,458,640.00
35470	Бусад хангамжийн материал	21,383,657.00	24,637,049.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>895,729,514.10</b>	<b>126,198,138.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	895,729,514.10	126,198,138.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	879,956,942.77	114,325,433.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	403,855,798.00	376,355,798.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(370,955,520.45)	(376,355,798.00)
39205	Машин тоног төхөөрөмж	2,461,005,027.09	355,994,903.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,663,568,436.99)	(300,144,781.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,661,820.51	235,727,069.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(181,041,745.39)	(189,469,358.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,962,075.00	17,179,675.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,962,075.00)	(4,962,075.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,772,571.33	11,872,704.65
39301	Программ хангамж	14,880,810.00	14,880,810.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,880,810.00)	(14,880,810.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,100,800.00	25,100,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(9,328,228.67)	(13,228,095.35)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>961,315,278.76</b>	<b>177,565,585.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,371,370.75</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,371,370.75	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	110,910.75	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	110,910.75	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	5,260,460.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,260,460.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>955,943,908.01</b>	<b>177,565,585.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	955,943,908.01	177,565,585.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,390,884.93	324,390,884.93
51101	Өмч: - төрийн	324,390,884.93	324,390,884.93
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	631,553,023.08	(146,825,299.84)
51210	Өмнөх үеийн үр дүн	(113,774,459.45)	631,553,023.08
51220	Тайлант үеийн үр дүн	745,327,482.53	(778,378,322.92)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>961,315,278.76</b>	<b>177,565,585.09</b>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,779,658,973.38</b>	<b>2,079,270,107.62</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,068,801,213.47	27,597,769.04
120	Нийтлэг татварын бус орлого	1,068,801,213.47	27,597,769.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,004,462,884.15	8,514,669.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,004,462,884.15	8,514,669.04
120009	Бусад орлого	64,338,329.32	19,083,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,710,857,759.91	2,051,672,338.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,661,365,700.00	2,031,815,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,661,365,700.00	2,031,815,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,084,800.00	19,856,738.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,084,800.00	19,856,738.58
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	407,259.91	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	407,259.91	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,026,566,789.07</b>	<b>7,240,827,897.49</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,026,566,789.07	7,240,827,897.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,927,163,058.79	7,133,135,934.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,036,350,521.00	1,149,333,082.00
210101	Үндсэн цалин	1,036,350,521.00	1,149,333,082.00
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	125,886,577.00	145,009,116.82
210201	Тэтгэврийн даатгал	84,680,643.00	100,120,089.79
210202	Тэтгэмжийн даатгал	10,501,526.00	11,778,834.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,422,976.00	9,192,668.16
210204	Ажилгүйдлийн даатгал	2,025,585.00	2,174,319.47
210205	Эрүүл мэндийн даатгал	20,255,847.00	21,743,204.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,392,230.00	22,445,460.00
210304	Байрны түрээс	14,392,230.00	22,445,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	104,297,820.52	85,602,415.28
210401	Бичиг хэрэг	53,093,596.00	21,675,183.00
210402	Тээвэр, шатахуун	17,232,314.00	17,776,393.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,857,916.72	14,219,071.28
210404	Ном, хэвлэл	-	19,083,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,113,993.80	12,848,668.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,921,850.00	4,950,000.00
210604	Урсгал засвар	4,921,850.00	4,950,000.00
2107	Томилолт, зочны зардал	26,416,576.00	25,121,395.00
210701	Гадаад албан томилолт	-	1,313,995.00
210702	Дотоод албан томилолт	26,416,576.00	23,807,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,646,198.32	5,501,611,853.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304,540,048.32	5,490,617,893.71
210803	Даатгалын үйлчилгээ	4,229,550.00	6,820,560.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	586,600.00	356,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	124,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,166,000.00	3,795,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302,251,285.95	199,062,612.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,143,480.00	23,895,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	291,107,805.95	175,167,112.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,403,730.28	107,691,962.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,053,517.98	102,197,663.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,644,057.98	45,034,715.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,809,460.00	57,162,948.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,350,212.30	5,494,299.59
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,350,212.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,494,299.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>753,092,184.31</b>	<b>(5,161,557,789.87)</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	5,000,000,000.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	-	5,000,000,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,764,701.78	616,820,533.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,764,701.78	616,820,533.05
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(7,764,701.78)</b>	<b>4,383,179,466.95</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР</b>	<b>745,327,482.53</b>	<b>(778,378,322.92)</b>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,774,788,829.32</b>	<b>2,070,755,438.58</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,338,329.32	19,083,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	64,338,329.32	19,083,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,710,450,500.00	2,051,672,338.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,661,365,700.00	2,031,815,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,661,365,700.00	2,031,815,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,084,800.00	19,856,738.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,084,800.00	19,856,738.58
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,760,223,829.32</b>	<b>2,056,813,838.58</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,760,223,829.32	2,056,813,838.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,646,688,609.04	1,962,432,023.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,026,940,800.00	1,160,604,300.00
210101	Үндсэн цалин	608,490,000.00	707,056,600.00
210102	Нэмэгдэл	367,032,600.00	402,129,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,248,500.00	145,075,600.00
210201	Тэтгэврийн даатгал	82,171,100.00	98,651,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,269,400.00	11,606,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,215,400.00	9,284,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,053,800.00	2,321,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,538,800.00	23,212,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,210,000.00	18,209,510.00
210304	Байрны түрээс	18,210,000.00	18,209,510.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,097,396.72	83,072,217.28
210401	Бичиг хэрэг	37,401,966.00	18,669,633.00
210402	Тээвэр, шатахуун	17,232,314.00	17,776,393.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,857,716.72	14,219,071.28
210404	Ном, хэвлэл	-	19,083,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,605,400.00	13,324,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,921,900.00	4,950,000.00
210604	Урсгал засвар	4,921,900.00	4,950,000.00
2107	Томилолт, зочны зардал	23,706,696.00	25,121,395.00
210701	Гадаад албан томилолт	-	1,313,995.00
210702	Дотоод албан томилолт	23,706,696.00	23,807,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	327,811,398.32	499,182,761.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	318,479,048.32	487,033,801.71
210803	Даатгалын үйлчилгээ	4,229,550.00	6,820,560.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	586,600.00	356,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,417,200.00	4,950,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,751,918.00	26,216,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,751,918.00	26,216,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,535,220.28	94,381,814.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,343,057.98	88,887,515.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,194,057.98	36,134,715.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,549,000.00	52,752,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,192,162.30	5,494,299.59
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,350,212.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,494,299.59
213304	Хөрөнгийн	10,841,950.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>14,565,000.00</b>	<b>13,941,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,565,000.00</b>	<b>13,941,600.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,565,000.00	13,941,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,565,000.00	13,941,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,565,000.00	13,941,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(14,565,000.00)</b>	<b>(13,941,600.00)</b>
14	Бусад эх үүсвэр	-	5,000,000,000.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	-	5,000,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	5,000,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	-	5,000,000,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>324,390,884.93</b>		<b>(113,774,459.45)</b>	<b>210,616,425.48</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93		(113,774,459.45)	210,616,425.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		745,327,482.53	745,327,482.53
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>324,390,884.93</b>		<b>631,553,023.08</b>	<b>955,943,908.01</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93		631,553,023.08	955,943,908.01
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		(778,378,322.92)	(778,378,322.92)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>324,390,884.93</b>		<b>(146,825,299.84)</b>	<b>177,565,585.09</b>



4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,031,815,600.00</b>	<b>7,029,963,250.41</b>	<b>1,852,349.59</b>	<b>99.9</b>
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,031,815,600.00	2,029,963,250.41	1,852,349.59	99.9
III. УРСГАЛ ЗАРДАЛ	2,031,815,600.00	2,029,963,250.41	1,852,349.59	99.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,305,679,900.00	1,305,679,900.00	-	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,604,300.00	1,160,604,300.00	-	100.0
Үндсэн цалин	707,056,600.00	707,056,600.00	-	100.0
Нэмэгдэл	402,129,500.00	402,129,500.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,200.00	-	100.0
Нийгмийн даатгалын шимтгэл	145,075,600.00	145,075,600.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	98,651,400.00	98,651,400.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	11,606,100.00	11,606,100.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	9,284,800.00	9,284,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,321,200.00	2,321,200.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	23,212,100.00	23,212,100.00	-	100.0
Бараа үйлчилгээний урсгал зардал	726,135,700.00	724,283,350.41	1,852,349.59	99.7
Бичиг хэргийн материал	19,017,400.00	18,669,633.00	347,767.00	98.1
Тээвэр, шатахууны зардал	13,670,400.00	17,776,393.00	(4,105,993.00)	130.0
Шуудан, холбооны зардал	15,000,000.00	14,219,071.28	780,928.72	94.8
Дотоод томилолтын зардал	23,807,400.00	23,807,400.00	-	100.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	16,310,200.00	13,324,020.00	2,986,180.00	81.7
Төлбөр хураамж, жижиг татварууд	13,426,300.00	12,148,960.00	1,277,340.00	100.0
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	483,944,500.00	483,544,608.13	399,891.87	100.0
Урсгал засварын зардал	4,950,000.00	4,950,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	89,002,800.00	88,887,515.00	115,285.00	99.8
Бусад зардал	28,796,700.00	28,746,240.00	50,460.00	99.8
Байрны түрээсийн зардал	18,210,000.00	18,209,510.00	490.00	100.0
<b>V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,031,815,600.00</b>	<b>7,031,815,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвөөс санхүүжих	2,031,815,600.00	2,031,815,600.00	-	100.0
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-	-	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	-		
Байгууллагын тоо	1	1	-	
Ажиллагсад бүгд	80	73	-	100.0
Удирдах ажилтан	13	13	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	60	53	7	88.3
Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		-
<b>ОРЛОГЫН ДҮН</b>		<b>19,856,738.58</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		19,856,738.58
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>		<b>19,856,738.58</b>
<b>А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>19,856,738.58</b>
1. Бараа үйлчилгээний зардал		16,214,788.58
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		16,214,788.58
Албан томилолт		9,014,788.58
Бусад төсөл арга хэмжээ		7,200,000.00
Татаас ба урсгал шилжүүлэг		3,641,950.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		3,641,950.00
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл		-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	2019 он	<b>Аудитын нэр:</b>	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/84/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Барилга, хот байгуулалтын яам</b>		<b>мянган төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тус яаманд "Дэд бүтэц төсөл" хэрэгжиж дууссантай холбогдуулан төслийн үйл ажииллагаанд ашиглаж байсан Hundai sonata-7 маркийн автомашиныг 2016 оны 12 сард балансасд шилжүүлсэн боловч одоогоор албан хэрэгцээнд ашиглагдахгүй байна. Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон уг автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй,	-	Зөвлөмж өгсөн	ТНБД, нягтлан бодогч	С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа
2	Тайлант онд Түрээсийн орон сууц корпораци ТӨХХК-нд "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний дагуу олгох 5.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн шууд захирагч /аппарат/-ийн төсөвт төлөвлөж, батлуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	ТНБД, нягтлан бодогч	С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа
	<b>Дүн</b>	-			

